



## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт шилжсэнтэй холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418, А/520 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор төвийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, төлөвлөгөөг шинэчлэн батлуулахыг Захиргаа, маркетингийн алба /Ч.Батболд/-д, цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг Цусны чанар, аюулгүй байдлын алба /Т.Алимаа/, Сувилахуй, үйлчилгээний алба /Б.Өнөрцэцэг/, Донор зохион байгуулалтын тасаг /Ч.Тунгалаг/, Нэгдсэн лабораторийн тасаг /М.Цэрэндэжид/, Үйлдвэрлэлийн тасаг /Н.Халиун/ нарт, цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Санхүү, бүртгэлийн алба /Б.Өнөрзул/, Инженер, техникийн тасаг /Ц.Энхмэнд/ нарт, хүний нөөцийн төлөвлөлт хийж, шаардлагатай нөхөн хангалтын арга хэмжээ хэрэгжүүлэхийг Хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д тус тус үүрэг болгосугай.

080344

3. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсвийн холбогдох зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн алба /Ч.Батболд/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР